

БАТЛАВ:

УУХҮЯ-НЫ ТӨВИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

МОНГОЛЫН ДАЛД УУРХАЙН МУЗЕЙ, СУРГАЛТ СУДАЛГАА, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ТӨВИЙН “ГАДНА ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖИЛ”-ЫН ДААЛГАВАР

2020 оны 03-р сарын 31

№ 03

Улаанбаатар хот

1	Гадна шугам сүлжээний ажлын үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын хуралдааны 25-р тэмдэглэл</li> <li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/158 дугаар тушаал</li> <li>- “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-ийн боловсруулан Барилга, хот байгуулалтын яамны барилгын хөгжлийн төвийн 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн магадлалын нэгтгэсэн дүгнэлтийн 368/2020 дугаар бүхий гадна шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв ЕГ шифр : ХТХ – 21/2019</li> </ul>
2	Захиалагч	УУХҮЯ-ны харьяа “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгж
3	Гүйцэтгэх ажлын нэр, байршил	<p>Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төвийн :</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ <b>Багц 1</b> - гадна цахилгааны хангамжийн ажил,</li> <li>➢ <b>Багц 2</b> - гадна дулааны шугам сүлжээний ажил,</li> <li>➢ <b>Багц 3</b> - гадна цэвэр усны шугам сүлжээний ажил,</li> <li>➢ <b>Багц 4</b> - гадна ариутгах татуургын шугам, 6,0 м<sup>3</sup>/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажил</li> </ul> <p>Хэнтий аймгийн Батноров сумын 7-р баг. Бэрхийн уурхайн уулын цех. Улаанбаатар хотоос 400 км, Чингис хотоос 70 км</p>
4	Гадна шугам сүлжээний өнөөгийн байдал	Уг уурхай нь 1994 онд хаагдаж, бүх инженерийн ба цахилгааны шугам сүлжээ нь хуучирч, тоногдож ашиглалтын шаардлага хангахгүй болсон. Төслийн хүрээнд өөрийн бие даасан дэд бүтцийн сүлжээг шинээр барьж байгуулах шаардлагатай.
5	Төслийн зорилго	Бэрхийн уурхай /Уулын цех/-г түшиглэн далд уурхайн музей, аялал жуулчлалын цогцолбор бүхий эрдэс баялгийн салбарын мэргэжлийн боловсон хүчний сургалт судалгааны төв байгуулах замаар цаашид уурхайчны мэргэжил, өв соёлыг хадгалах, залуу хойч үед өвлүүлэн сурталчлах, уул уурхайн мэргэжлийн оюутан судлаачдад үйлдвэрлэлийн дадлага хийх сургалт судалгааны бааз бий болгох, Монголд уул уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн жишиг тогтоох, олон улсын жишигт хүргэх, Бэрх тосгоныг хөгжүүлэх, шинэ ажлын байр бий болгох, Монгол Улсын зүүн бүсийн түүхэн аялал жуулчлалын маршрутад холбон оруулах
6	Зориулалт	Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төвийн нийт 7 барилга байгууламжийг дулаан, бохир зайлуулах, цэвэр халуун хүйтэн ус, цахилгаан эрчим хүчээр хангана. Үүнд:

		<ul style="list-style-type: none"> <li>• Музейн төв</li> <li>• Сургалтын төв</li> <li>• Мэдээллийн төв</li> <li>• Урлан үзмэрийн барилга</li> <li>• Дотуур байрны барилга</li> <li>• Зочид буудлын барилга</li> <li>• Уурын зуухны барилга</li> </ul>
7	Ажиллах горим	Төслийн үйл ажиллагааны явцад тасралтгүй байнга ажиллана.
8	Шугам сүлжээ, инженерийн байгууламжийн үндсэн бүтээц материал	Төслийн талбайн гадаргууд ухаж татсан шуудуунд: төмөр бетон хийцүүд, элс, тулгуур дэрүүд, ган хоолой, хуванцар хоолой, хучилт, төмөр хийц,
9	Гадна шугам сүлжээ түүнийг хангах эх үүсвэр	<p><b>Цахилгаан хангамж:</b> Техникийн нөхцөлөөр ЛЭЗҮ-ийн нөхцөлөөр/-БЗӨБЦТС ТӨХК-ийн захирлын 2020 оны 3-р сарын 6-ны өдрийн ХЭ 20/02-01 дугаар цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл</p> <p><b>Холбоо дохиолол:</b> Техникийн нөхцөлөөр ЛЭЗҮ-ийн нөхцөлөөр/-Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн Хэнтий аймгийн газрын даргын 2020 оны 2-р сарын 6-ны өдрийн А-01 дугаар техникийн нөхцөл</p> <p><b>Дулаан хангамж:</b> Төслийн талбайд бие даасан бага оврын уурын зуух шинээр төлөвлөж, дулааны шугам сүлжээг татаж тоноглон барилга байгууламжуудыг дулаанаар хангана.</p> <p><b>Ус хангамж:</b> Төслийн талбайд шинээр гүний худаг гаргаж бие даасан эх үүсвэрээс барилга байгууламжуудыг цэвэр усаар хангана.</p> <p><b>Ариутгах татуурга:</b> Шинээр баригдах ариутгах татуургын байгууламжид холбох</p>
10	Ажлын гүйцэтгэлд тавигдах шаардлага	<p>“Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-ийн боловсруулан Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвийн 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн магадлалын нэгтгэсэн дүгнэлтийн 368/2020 дугаар бүхий гадна шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв /ЕГ шифр : ХТХ – 21/2019/-т тусгагдсан ажлуудыг зураг төслийн дагуу гүйцэтгэж зохих журмын дагуу улсын комисст хүлээлгэж өгнө.</p> <p>Уг барилгын цахилгаан хангамж, дулаан, халуун хүйтэн ус ариутгах татуургыг зураг төсөлд зааснаар гүйцэтгэж гадна шугам сүлжээнд холбож туршилт хийж хүлээлгэж өгнө.</p>
11	Тендерт компанид оролцох шаардлага тавигдах	<ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч компани нь ижил төстэй ажлыг урьд өмнө нь 5-аас доошгүй жил гүйцэтгэж байсан туршлагатай, тусгай зөвшөөрөлтэй байх</li> <li>- Тендер зарлагдах үед татварын болон НДШ-ийн өргүй байх</li> <li>- Сүүлийн 2 жилийн аль нэгэнд компанийн борлуулалтын орлого тендерт зарлагдсан төсөвт өртгөөс дээш байх</li> <li>- Уг ажлыг гүйцэтгэх ажиллах хүчний чадавхтай байх (тендерт ирүүлэх материалд жагсаалтаар хавсаргах)</li> <li>- Ажил гүйцэтгэх баталгаа (дэнчин) тендерт зарлагдсан төсөвт өртгийн 2%-тай тэнцэх шалгуурыг зөвшөөрсөн байх</li> <li>- Гүйцэтгэсэн ажлын баталгаат хугацаа 2 жилээс доошгүй байх шаардлагыг зөвшөөрсөн байх</li> </ul>

12	Хууль эрх зүйн орчин, өнөөгийн мөрдөж буй норм, хэм хэмжээ, стандарт	<p><b><u>Хууль</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын тухай хууль,</li> <li>- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,</li> <li>- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль,</li> <li>- Монгол улсын холбогдох бусад хууль</li> </ul> <p><b><u>Норм, стандартууд</u></b></p> <p><b><u>1. Гадна цахилгааны ажил:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03</li> <li>- Цахилгаан байгууламжийн дүрэм /нэмэлт бүлгүүд/ ЭХД-1-13-01-2006</li> <li>- Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23-01-09</li> <li>- Барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах төлөвлөлт БНБД 20-02-11</li> <li>- Цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон конусан шон MNS 4232:2011</li> <li>- Агаарын шугамын дамжуулах утас MNS 5870:2008</li> <li>- IEC 60502-1997</li> <li>- Цахилгаан техникийн ажил БНБД 3.05.06.90</li> <li>- Зураг төсөвт заагдсан бусад норм, стандартууд</li> </ul> <p><b><u>2. Гадна дулааны ажил:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дулааны сүлжээ БНБД 41-02-13</li> <li>- Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23-01-09</li> <li>- Зураг төсөвт заагдсан бусад норм, стандартууд</li> </ul> <p><b><u>3. Гадна цэвэр, бохир усны ажил:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16</li> <li>- Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-14, БНБД 40-01-06</li> <li>- Зураг төсөвт заагдсан бусад норм, стандартууд</li> </ul> <p><b><u>4. Бусад:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт БНБД 12-01-03</li> <li>- Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. I хэсэг. Ерөнхий шаардлага. БНБД 12-03-04</li> <li>- Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм. БНБД 12-04-06</li> <li>- Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн загвар. БД 12-101-05</li> <li>- Барилгын инженер-геологи, геотехникийн ажилд мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм. Үндсэн шаардлага. БД 12-102-04</li> <li>- Барилгын гадна ханын шаардлагатай дулаан тусгаарлалтын ажлын техникийн дүрэм. БД 12-103-07</li> <li>- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04</li> </ul>
13	Хөрөнгө оруулалт	Улсын төсөв

14	Ажлын төсөвлөсөн өртөг	1. Багц 1 : 189,076,394 ₮ 2. Багц 2 : 258,066,130 ₮ 3. Багц 3 : 61,231,170 ₮ 4. Багц 4 : 70,101,477 ₮
15	Онцгой нөхцөл	Газар хөдлөлтийн чичирхийлэл: 7 балл. Гадна агаарын температур +30° С, -40° С Цасны ачаалал: 50кг/м <sup>2</sup> Салхины ачаалал: 35кг/м <sup>2</sup> Барилгын төрөл: 2 Галд тэсвэрлэлтийн чанар: II Гадна тохижилт, явган хүний зам, талбай, орц, гарцын төлөвлөлттэй уялдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй нэвтрэх боломжтой байдлаар зураг төслийн дагуу барих Ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэнэ.
16	Галын аюулгүй байдлын нөхцөл	"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНБД 21-02-02, "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл" БНБД 21-04-05 норм, дүрмүүдээс холбогдох заалтуудыг дагаж мөрдөх
17	Байгаль орчны үнэлгээ	Шаардлагатай нөхцөлд үнэлгээг тухай бүрд нь хийнэ.
18	Ажлын эхлэх болон дуусах хугацаа	Эхлэх хугацаа: 2020.05.15 Дуусах хугацаа: 2020.10.01

ХЯНАСАН:

ХҮНД ҮЙЛДВЭР, ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.АНХБАЯР

С.СҮХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

МОНГОЛЫН ДАЛД УУРХАЙН МУЗЕЙ, СУРГАЛТ  
СУДАЛГАА, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ  
ТӨСЛИЙН НЭГЖИЙН ЗАХИРАЛ

 Н.БАТБОЛД